

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2023/103/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Чойбалсан хот 2023 он	Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 215

танай _____-ны № _____-т

ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БАТСҮХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд, холбоо барих

011020200

мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>506,132,702.19</u>	<u>715,892,211.54</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	186,071,469.94
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	186,071,469.94
3121	Төгрөг	-	186,071,469.94
31211	Төрийн сангийн харилцах	-	186,071,469.94
35	БАРАА МАТЕРИАЛ	506,132,702.19	529,820,741.60
354	Хангамжийн материал	506,132,702.19	529,820,741.60
35410	Бичиг хэргийн материал	1,221,900.00	655,890.00
35420	Аж ахуйн материал	1,873,210.00	111,500.00
35470	Бусад хангамжийн материал	503,037,592.19	529,053,351.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,870,461,736.99</u>	<u>2,935,054,585.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,870,461,736.99	2,935,054,585.50
392	Биет хөрөнгө	2,603,962,841.15	2,668,829,314.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,778,475,753.00	2,826,360,206.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(218,723,510.36)	(315,051,619.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	289,854,474.69	397,410,164.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	(249,037,040.81)	(252,285,109.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,812,014.00	18,812,014.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,418,849.37)	(16,752,107.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	147,536,000.00	147,536,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(147,536,000.00)	(147,536,000.00)
39217	Ном	-	10,335,767.00
393	Биет бус хөрөнгө	266,498,895.84	266,225,270.88
39301	Програм хангамж	1,094,500.00	1,094,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(45,604.16)	(319,229.12)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,376,594,439.18</u>	<u>3,650,946,797.04</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,376,594,439.18</u>	<u>3,650,946,797.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,376,594,439.18	3,650,946,797.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	937,080,377.99	937,080,377.99
51101	Өмч: - төрийн	937,080,377.99	937,080,377.99
512	Хуримтлагдсан үр дүн	1,695,464,386.51	1,969,816,744.37
51210	Өмнөх үеийн үр дүн	1,695,464,386.51	(1,681,130,052.67)
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,650,946,797.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	744,049,674.68	744,049,674.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,376,594,439.18</u>	<u>3,650,946,797.04</u>

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,214,066,307.88	6,470,070,732.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	378,575,641.88	3,489,934,636.18
120	Нийтлэг татварын бус орлого	219,578,029.48	3,489,934,636.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	219,578,029.48	10,680,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,530,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	150,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	219,578,029.48	
120017	үнэ төлбөргүй авсан орлого Үндсэн хөрөнгө	-	2,943,531,656.99
120018	Үнэ төлбөргүй авсан орлого Бараа материал	-	535,722,179.19
121	Хөрөнгийн орлого	107,818,112.40	
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	107,818,112.40	
122	Тусламжийн орлого	51,179,500.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,835,490,666.00	2,980,136,096.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,721,006,000.00	2,692,000,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,721,006,000.00	2,692,000,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,484,666.00	147,731,496.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,484,666.00	147,731,496.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		140,403,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		140,403,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,040,468,212.32	2,819,123,935.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,040,468,212.32	2,819,123,935.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,855,229,728.32	2,366,120,870.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,415,222,716.00	1,820,465,126.37
210101	Үндсэн цалин	875,708,016.00	1,209,510,849.54
210102	Нэмэгдэл	447,987,858.00	523,478,009.57
210104	Урамшуулал	91,526,842.00	87,476,267.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,415,703.00	226,405,599.69
210201	Тэтгэврийн даатгал	129,538,532.00	155,378,429.11
210202	Тэтгэмжийн даатгал	14,299,446.00	18,289,331.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,436,555.00	14,577,706.85
210204	Ажилгүйдлийн даатгал	2,649,197.00	3,466,914.61
210205	Эрүүл мэндийн даатгал	26,491,973.00	34,693,217.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,830,685.00	68,831,896.11
210301	Гэрэл, цахилгаан	10,899,775.00	17,417,360.90

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	28,462,910.00	31,368,715.21
210303	Цэвэр, бохир ус	6,468,000.00	20,045,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,020,768.00	12,104,616.00
210401	Бичиг хэрэг	3,494,313.00	783,100.00
210402	Тээвэр, шатахуун	718,100.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	534,730.00	
210404	Ном, хэвлэл	9,254,940.00	10,061,356.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,376,065.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,642,620.00	1,260,160.00
2105	Нормативт зардал	2,343,000.00	956,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	904,800.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,438,200.00	956,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	4,500,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,100,000.00	10,530,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,100,000.00	10,530,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,796,856.32	222,326,032.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	74,446,415.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,057,889.58	35,646,045.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	151,738,966.74	112,233,571.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185,238,484.00	453,003,064.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	160,027,188.00	437,199,981.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,638,600.00	258,086,085.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,068,604.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,819,984.00	147,731,496.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	31,382,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,211,296.00	15,803,083.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,211,296.00	15,803,083.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>173,598,095.56</u>	<u>3,650,946,797.04</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	27,619,218.32	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	27,619,218.32	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(27,619,218.32)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>145,978,877.24</u>	<u>3,650,946,797.04</u>

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,886,670,166.00</u>	<u>2,990,816,896.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,179,500.00	10,680,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	51,179,500.00	10,680,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,680,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,530,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	150,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,835,490,666.00	2,980,136,096.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,721,006,000.00	2,692,000,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,721,006,000.00	2,692,000,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,484,666.00	147,731,496.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,484,666.00	147,731,496.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		140,403,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		140,403,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>1,886,670,166.00</u>	<u>2,700,988,926.06</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,886,670,166.00	2,700,988,926.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,701,431,682.00	2,247,985,861.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,415,222,716.00	1,820,465,126.37
210101	Үндсэн цалин	875,708,016.00	1,209,510,849.54
210102	Нэмэгдэл	447,987,858.00	523,478,009.57
210104	Урамшуулал	91,526,842.00	87,476,267.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,415,703.00	226,405,599.69
210201	Тэтгэврийн даатгал	129,538,532.00	155,378,429.11
210202	Тэтгэмжийн даатгал	14,299,446.00	18,289,331.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,436,555.00	14,577,706.85
210204	Ажилгүйдлийн даатгал	2,649,197.00	3,466,914.61
210205	Эрүүл мэндийн даатгал	26,491,973.00	34,693,217.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,830,685.00	68,831,896.11
210301	Гэрэл, цахилгаан	10,899,775.00	17,417,360.90
210302	Түлш, халаалт	28,462,910.00	31,368,715.21
210303	Цэвэр, бохир ус	6,468,000.00	20,045,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,284,078.00	
210401	Бичиг хэрэг	3,535,213.00	
210402	Тээвэр, шатахуун	701,290.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	534,730.00	
210404	Ном, хэвлэл	365,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,436,365.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,711,480.00	
2105	Нормативт зардал	2,321,900.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	904,800.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,417,100.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	4,500,000.00

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	4,500,000.00	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,100,000.00	34,671,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,100,000.00	10,530,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	24,140,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,756,600.00	93,112,139.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	57,466,094.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,756,600.00	35,646,045.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185,238,484.00	453,003,064.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	160,027,188.00	437,199,981.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,638,600.00	258,086,085.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,068,604.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,819,984.00	147,731,496.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	31,382,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,211,296.00	15,803,083.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,211,296.00	15,803,083.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>289,827,969.94</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	103,756,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	103,756,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	103,756,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	103,756,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(103,756,500.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	186,071,469.94
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	186,071,469.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	937,080,377.99	744,049,674.68	1,695,464,386.51	3,376,594,439.18
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	937,080,377.99	744,049,674.68	1,695,464,386.51	3,376,594,439.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,376,594,439.18)	(3,376,594,439.18)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	937,080,377.99	744,049,674.68	(1,681,130,052.67)	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	3,650,946,797.04	3,650,946,797.04
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	937,080,377.99	744,049,674.68	1,969,816,744.37	3,650,946,797.04

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,848,865,400.00	2,657,013,930.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,848,865,400.00	2,657,013,930.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,539,708,316.11	2,351,742,361.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,965,802,128.00	1,820,465,126.37
210101	Үндсэн цалин	1,424,145,594.00	1,209,510,849.54
210102	Нэмэгдэл	494,852,992.00	523,478,009.57
210104	Урамшуулал	46,803,542.00	87,476,267.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,579,492.00	226,405,599.69
210201	Тэтгэврийн даатгал	167,025,170.26	155,378,429.11
210202	Тэтгэмжийн даатгал	19,650,018.75	18,289,331.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,720,015.95	14,577,706.85
210204	Ажилгүйдлийн даатгал	3,925,844.14	3,466,914.61
210205	Эрүүл мэндийн даатгал	39,258,442.90	34,693,217.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,831,896.11	68,831,896.11
210301	Гэрэл, цахилгаан	17,417,360.90	17,417,360.90
210302	Түлш, халаалт	31,368,715.21	31,368,715.21
210303	Цэвэр, бохир ус	20,045,820.00	20,045,820.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	4,500,000.00
210604	Урсгал засвар	20,303,083.89	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,671,100.00	34,671,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,530,800.00	10,530,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,140,300.00	24,140,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	220,323,700.00	196,868,639.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	184,113,300.00	161,222,594.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,210,400.00	35,646,045.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	309,157,083.89	305,271,568.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	293,354,000.00	289,468,485.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	261,971,600.00	258,086,085.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,382,400.00	31,382,400.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,848,865,400.00	2,843,085,400.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,692,000,800.00	2,692,000,800.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,692,000,800.00	2,692,000,800.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,460,800.00	10,680,800.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,530,800.00	10,530,800.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,930,000.00	150,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1.00	186,071,469.94
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	140,403,800.00	140,403,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	140,403,800.00	140,403,800.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	147,731,496.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	147,731,496.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,731,496.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	147,731,496.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	147,731,496.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	147,731,496.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	147,731,496.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	147,731,496.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 17 дугаар зүйлийн 17.1. “Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана”, 30.4. “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 30.4.1 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 30.4.2 “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.					1	-							
Дүн					1	-							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах таван сая төгрөгнөөс дээш худалтан авалтын 1 мэдээлэлийн мэдээллийг мэдээлээгүй байна.	1	50,852.5							1	50,852.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд гэрэл цахилгаан, дулааны зардалд Тайлант хугацаанд 68,831.9 мянган төгрөг зарцуулсан ба өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 23,001.2 мянган төгрөгөөр өссөн байна.	1	23,001.2							1	23,001.2
Дүн	2	73,853.7							1	73,853.7



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 99/01 ДООА-2023/103/НА-СТА-ТШЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 17 дугаар зүйлийн 17.1. "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 30.4. "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 30.4.2 "энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах", 30.4.3 "энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

011040411

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн захирал Б.Батсүх, нягтлан бодогч Б.Баттөр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

 И.СЭМЖИДМАА

 Д.АРИУНАА